



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2019 оны 05 сарын 01 өдөр

Дугаар А/246

Булган

**Гэрээ байгуулах эрх
олгох тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2 дахь заалт, аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хуралдааны 2018 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 10/07 дугаар тогтоолын тавдугаар хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн 2019 оны төлөвлөгөөнд тусгагдсан “Ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, арчилгаа хийх” төсөл, арга хэмжээний зардлаас Хишиг-Өндөр сумын Засаг дарга /С.Мөнхтөр/-д 2 000 000 /хоёр сая/ төгрөгийн эрх шилжүүлсүгэй.

2. Ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, арчилгаа хийх ажлын үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомж, гэрээний дагуу Байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг нөхөн сэргээх арга хэмжээний зардлын “Ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, арчилгаа хийх” зардлаас санхүүжүүлэхийг нягтлан бодогч /Б.Очирсүрэн/-д зөвшөөрсүгэй.

3. Эрх шилжүүлсэн хөрөнгийг хууль, журмын дагуу зохион байгуулж, гэрээ байгуулан гүйцэтгэлд нь тогтмол хяналт тавьж, чанарын өндөр түвшинд хүлээн авахыг Хишиг-Өндөр сумын Засаг дарга /С.Мөнхтөр/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



З.БАТЗОРИГ

D:\ЗДТГ,ХОХБТХ\Захирамж

20190266